

БАТЛАВ.



МОНГОЛЫН АНАГААХ
УХААНЫ ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.АМАРСАЙХАН

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН
ХӨГЖЛИЙН
НИЙГЭМЛЭГИЙН ТЭРГҮҮН
Ө.АНХБОЛД



ЗАЙН СУРГАЛТЫН ВИДЕО ХИЧЭЭЛ БЭЛТГЭХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2016 10 18 04 5

2016 оны 10 -р сарын 10-ны өдөр

№....

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид захиалагч гэх/ -ийг төлөөлж *Салбар дундын хэлтэсний ажиллагаа ОНХ шэргэлтэн Б.Нэгсүрэн* нөгөө талаас Монголын Анагаах Ухааны Холбоог төлөөлж *наршин Биглэний дарга Ц.Хотгорсүр* Яаралтай тусламжийн хөгжлийн Нийгэмлгийг төлөөлж *наршин Биглэний дарга Д.Солонго* /цаашид гүйцэтгэгч гэх/ хамтад нь талууд гэх/ нар нь дараах нөхцлөөр харилцан тохиролцож 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2016 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Эрүүл мэндийн салбарт мэргэжил дээшлүүлж буй эмч эмнэлгийн ажилтнуудад яаралтай тусламжийн үед авах арга хэмжээ, ард иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэхэд авах арга хэмжээг олон нийтэд хүргэх зайн сургалтын видео хичээлийг үе шаттайгаар бэлтгэх үүргийг зохицуулахаар харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Талууд гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэн гарын үсгээр баталгаажуулна.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 ЭМХТ-ийн эрх, үүрэг:

- 2.1 Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгчээс гэрээний дагуу зайн сургалтын хичээлийг шаардах эрхтэй,
- 2.2 Гэрээт ажлын явцад хяналт тавьж чанар болон гүйцэтгэлийн талаар санал гомдол гаргах эрхтэй,
- 2.3 Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд эд хөрөнгийн болон эрхийн доголдол бий болсон нөхцөлд өөрт учирсан хохирлыг гүйцэтгэгч талуудаас шаардах эрхтэй,

2.4 Гэрээний хүрээнд хийгдэх зайн сургалтын 10 дугаарыг бэлтгүүлэн хүлээн авах эрхтэй,

2.5 Зайн сургалтын хичээлийн зохиогчийн эрхийг эзэмшинэ,

2.6 Зайн сургалтын хичээлийг хүлээн авахдаа бүх дугаарыг AVI форматаар софтоор болон DVD-гээр хүлээн авна.

2.7 Зайн сургалтын хичээл бэлтгэхэд оролцогчид болон зураг авалтыг хөдөө орон нутаг, гадаад оронд авах зорилгоор өөр ивээн тэтгэгч олж болох ба түүнийгээ өөрөө захиран зарцуулах эрхтэй,

2.8 Зайн сургалтын хичээлийг чанартай гүйцэтгүүлэхийн тулд зарим тохиолдолд туслан гүйцэтгэгч болон зөвлөх баг авч ажиллуулж болох бөгөөд санхүүжилтийг хариуцна.

2.9 Техникийн болон эфирийн шаардлага хангасан зохиомж утга агуулга үнэн зөв бодит байдлыг илэрхийлсэн видео хичээлийг шаардах эрхтэй,

2.10 Гэрээнд заасан хугацаанд санхүүжилтийг шилжүүлэх үүрэгтэй,

2.2 Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:

2.2.1 Захиалагчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй байх,

2.2.2 Гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд бэлтгэн хүлээлгэн өгөх,

2.2.3 Захиалагч талаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

2.2.4 Зайн сургалтын хичээлийг олон нийтэд сурталчилах үүрэгтэй,

2.2.5 Гэрээний шаардлагын дагуу техник хэрэгсэл хүн хүчийг урьдчилан бэлтгэсэн байна,

2.2.6 Гэрээт ажлыг чанартай шуурхай гүйцэтгэн хүлээлгэж өгөх үүрэгтэй,

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

3.1 Энэхүү гэрээний нийт төлбөр болох 39,000,000 / гучин есөн / сая төгрөгийг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлнэ.

3.2 Гэрээний үнийн дүнгийн урьдчилгаа төлбөр болох 60 хувийг гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

3.3 Үлдэгдэл төлбөрийг ажил хүлээлцэх акт үйлдэгдсэнээс хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

4.1 Энэхүү гэрээний харилцаатай холбоотой холбогдон гарч болзошгүй бүх санал зөрчилдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд уг асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.3 Талууд төрийн ашиг сонирхлыг дээдлэн, хувийн ашиг сонирхлын үүднээс хууль бус үйлдэл гаргахгүй ажиллах буюу аливаа ашиг сонирхлын зөрчил байгаа болон түүнийг мэдэж байгаа тохиолдолд гэрээг байгуулахаас өмнө ил тод мэдэгдэнэ.

4.4 Гэрээний хувиуд адил тэгш хүчинтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээнд аль нэг талын санаачилгаар нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчилж болох бөгөөд энэ тохиолдолд бусад талуудад урьдчилан мэдэгдсэн байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийг төлөөлж




Б. Намсурэн

Монголын анагаах ухааны холбоог
төлөөлж



У. Жамбаяв

Яаралтай тусламжийн хөгжлийн
Нийгэмлгийг төлөөлж



Д. Салонго